

ХОШИН, ШОГ НИЙТЛЭЛИЙН ОНЦЛОГ, МӨН ЧАНАР

Н. Мөнхзориг*

* "Идэр" дээд сургууль, Монгол хэл, Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, магистр, докторант

Түлхүү үг: хошин, шог зохиол, хошигнол, шоглол, инээдэм, эсрэг дүр, яруу сайхны инээдэмт харьцаа, адилтгал, зүйрлэл, ихэсгэл, давуулал, хэтрүүлэл

Аливаа хошин, шог зохиол, түүний дотор хошин, шог нийтлэлийн төвд инээдэмт явдал байдаг. Инээдэмт явдал нь амьдралын ямарваа нэг зөрчлөөс үүдэн гардаг байна. Инээдмийг бий болгож буй үзэгдэл нь өөртэйгээ буюу бусад үзэгдэлтэй заавал харшилсан байдаг онцлогтой. Инээд бол хүн зөрчил тэмцэлд ялагдсаны биш, харин ялан дийлсний бэлгэ тэмдэг мөн. Иймээс инээд нь хүн эрүүл саруул, зол жаргалтай байгаагийн илэрхийлэл болдог.

Инээдэмт явдлыг тусган үзүүлэх төдийгүй, олж харахад уран бүтээлчээс өвөрмөц авьяас билиг шаардагддаг. Уг өвөрмөц авьяас билиг нь аливаа үзэгдэлд оршиж буй инээдэмт шинжийг бусдаас түрүүнд олж харах, түүнийг илэрхийлэх чадвараар хэмжигддэг юм. Уран бүтээлч болгон хошин, шог зохиолч байж чаддаггүйн учир үүнтэй холбоотой.

Шог зохиолд ихэнхдээ эсрэг дүрийг бүтээдэг. Ер нь уран бүтээлд эсрэг дүрийг хичнээн тод дүрсэлнэ, эерэг талын дүр төчнөөн хүчтэй болдог хуультай. Гэхдээ «дайсан»-ы дүрийг тод дүрсэлнэ гээд бодит байдлаас дэгсдүүлэн харлуулж болохгүй. Энэ

шаардлагын гол утга нь эсрэг баатрыг хэт арчаагүй байдлаар дүрсэлж болохгүй, бодитоор нь тусгавал зохилтой гэсэн үг болно. Эс тэгвэл, өөрөөр хэлбэл дүр хэт арчаагүй, хэт сөрөг болсноор дэвшүүлж буй асуудлын тулгамдсан чанар алдагдах, хүчгүй болох, нөлөөлөл нь мөлийх талтай.

Хошин, шог зохиолын инээдэм нь хоёр янз байна. Утга зохиол судлаач, шүүмжлэгч Ц. Мөнх энэ талаар бичихдээ: «Бодит байдалд харьцах яруу сайхны инээдэмт харьцаа дотроо олон янз, өнгөтэй юм. Түүнийг үндсэнд нь хошин, шог гэж хоёр ангилан үзэж болно. Шог инээд (сатира) бол хорсон үгүйсгэсэн шүүмжлэл байдаг бол хошин инээд (юмор) хоргүй хошигнол, нөхөрсөг шүүмжлэлийн шинжтэй байдаг. Шог инээд нь хайр найргүй, эрс тэс, үзэн ядсан ... инээдмийн бай, объект болж байгаа үзэгдлийг уг үндсээр нь эсэргүүцэн бут ниргэсэн уур хилэнт догшин инээд юм. Энэ утгаараа шог инээд нь инээдмийн хамгийн хүчтэй хэлбэр мөн»¹ гэжээ.

Академич Х. Сампилдэндэвийн онцолсноор, хошин, шог зохиол нь утга учиргүй инээд биш, ухаалаг инээдэм байх ёстой². Мөн судлаачийн үзсэнээр нийгмийн захиалгат сэдвийг тусгаснаар хошин, шог зохиол ямагт цаг үеэ олсон асуудлыг хурцаар дэвшүүлсэн дайчин шинжтэй байдаг төрөл, зүйлийн онцлогоо хадгалж, хөгжил, хөдөлгөөнд эрч хүч өгөх учиртай³.

Хошин, шог нь бодит байдалд шүүмжлэлтэй хандах яруу сайхны харьцаа болохынхоо хувьд гоо сайхны эрхэм дээд эрмэлзэл, хамт олон, нийгмийн үзэл бодол, үнэт зүйлд нийцсэн эрүүл инээдэм байж гэмээнэ нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, сургамжтай шүүмжлэл болдог. Хошин, шог зохиол, нийтлэл уран чадварын хувьд үлбэгэр болдгийн нэг шалтгаан нь шүүмжлэх маягаар баримтыг шууд тоочиж, шоглол, хошигнол, инээдмийг хомсдуулсантай холбоотой юм.

Судлаач Ш. Гүндалайн тодорхойлсноор, хошигнол, шоглол нь инээдмийн үндсэн хоёр хэлбэр мөн. Хошигнол нь юмс үзэгдлийн дутагдлыг улам тод томруун болгож, мөн чанарыг бүрэн дүүрэн нээн харуулдаг. Энэ утгаараа хошигнолын хувьд бидний алдаа дутагдал нь ололт амжилтын нэгэн хүчин зүйл болдог. Тэгвэл нийгэмд аюултай, хортой үзэгдлийг бүхэлд нь үгүйсгэн эсэргүүцэж, төгөлдөр бусыг яллан «цаазалж», үндсээр нь өөрчлөхийг гол зорилгоо болгох нь шоглолын уугуул дүр төрх, чинхүү зорилт мөн⁴.

Хошин, шог нийтлэл нь хошин, шог зохиолоос зарчмын хувьд ялгаагүй. Шог нийтлэл нийгэм, улс төрийн эгзэгтэй, эдрээтэй, олон нийтийн үнэт зүйл, үзэл сурталд харшилсан юм, үзэгдлийг элэглэн шоглох замаар жигшин зэвүүцэх сэтгэлийг уншигчдад төрүүлдэг бол хошин нийтлэлийн сэдэв нь нийгэмд гойд аюултай хэрэг байдаггүй. Гол төлөв нийгэм, хамт олны нэг гишүүний хөдөлмөрлөж тэмцэж яваа хүний гэнэн алдаа, санамсаргүй төөрөгдөл мэтийн хөгтэй явдал байдаг.

Шог зохиолд уран бүтээлчийн сайн сайхны туйлын хүсэл эрмэлзлийн эрс эсрэг үзэгдэл дүрслэгддэг. Ч. Ойдовын «Далан худалч» жүжигт ард түмнийг сорон мөлжигч гадаад, дотоодын дарлагч ангийнхныг хурц шог дүрээр тусган үзүүлсэн байдаг. Шог инээдмийн зохиолд хэтрүүлэл, егөөдөл, ёгтлол зэрэг уран сайхны хурц, хүчтэй аргыг

элбэг хэрэглэдэг. Шог инээдэм бол дэвшилт тэргүүний үзэгдлийн эзэлбэл зохих байран дээр оршиж байгаа хуучны хоцрогдмол үзэгдлийн эсрэг чиглэсэн шинжтэй юм.

Шог зохиол бичнэ гэдэг нь хялбаргүй нарийн ажил. Оросын нэрт зохиолч С. Михалков: «Шог зохиол бол хэн нэгнийг заавал дайрч хөндөж, хэн нэгнийг гомдоож, хэн нэгэнд таалагдаггүй төрөл, зүйл юм. Шог зохиол бүх нийтийн алга ташилтгүйгээр хөгжиж чадахгүй» гэж хэлсэн байдаг. Үнэхээр ч шог инээдмийн дүрүүдээс үзэгчид өөрийгөө, танил нэгнээ олж харж, гомдож, эсэргүүцэж, тэмцэж, хариу шүүмжилж эхэлдэг байна. Энэ бол урлагийн дайчин хүч чадлыг батлан үзүүлж байгаа хэрэг билээ.

Гэхдээ шог инээдэм, шог зохиол гэдэг бол маш хурц зэвсэг гэдгийг анхаарах нь чухал. Нэрд гарсан шог зохиолчид, гоо зүйн онолчид шог инээдмийг эвгүй хэрэглэвэл эрүүл биеийг гэмтээж болох хоёр талдаа иртэй хутга, болгоомжгүй ажиллавал эрхэм эдийг төөнөн түлж мэдэх гал цог юм гэж олонтаа зүйрлэн сургасан байдаг. Шог гэдэг хурц мэсийг барихад зохих хэмжээний уран чадвар, ухаан бодол, хүч чадлыг шаардана. Үеэ дуусгаж мөхөж яваа зүйлийг авч хаяхдаа эрүүл чийрэг махбодыг гэмтээж болохгүй. Энэ ч учраас авьяаслаг шог зохиолчдыг сайн мэс засалчтай зүйрлэдэг тухай доктор С. Лувсанвандан⁵ тэмдэглэжээ.

Хошин инээд бол амьдрал урлагийн аль алинд хамгийн түгээмэл дэлгэрсэн байдаг. Уран хошин үг хэлдэггүй хүн, уран хошиноор дүрсэлж үзээгүй зохиолч гэж бараг байхгүй юм. Хошин зохиолд уран бүтээлчийн сайн сайхны хүсэл эрмэлзлийн дагуу үзэгдэл дүрслэгддэг.

Манай ард түмэн аман болон бичгийн хошин, шог зохиолын арвин өвтэй. Бадарчны үлгэр, Баруун Монголын хошин, шог дуу зэрэг аман яруу найргийн бахархам бүтээл манай ард

түмний хошин, шог авьяас билгийн илэрхийлэл болон бидэнд үлджээ.

Хошин, шог зохиолч, нийтлэлч Д. Даржаагийн онцолсноор, шог зохиолд зүйрлэл хэрэглэх нь маш нарийн төвөгтэй асуудал юм. Шог зохиолд зүйрлэлийг олон янзаар хэрэглэх боловч ямар нэг журам зарчим байхгүй. Шоглохын төлөө шог гэж байж болохгүй. Шог зохиолын зүйрлэлийг зөв бөгөөд мэдрэмжтэй хэрэглэх ёстой. Тийм болохоор шог инээдмийн зохиол заавал дайрч хатгасан, харааж зүхсэн, аль муу муухай зүйлтэй зүйрлэсэн байхыг шаардахгүй. Бас шог зохиол хэдий чинээ хурц бөгөөд инээдэмтэй бичигдэнэ, алдаа дутагдлын хор холбогдлыг төдий чинээ ойлгуулан жигшүүлэх юм. Үүнд шог зүйрлэл их үүрэгтэй⁶. Сайн зохиол бол эцсийн эцэст юу үзүүлж, юу хэлэх гэснээ ойлгуулж чаддаг. Тэр ойлголтыг өгөхөд зүйрлэл онцгой хэрэгтэй. Манай ардын аман зохиол,

мөн шинэ үеийн хошин, шог зохиолчдын зохиол, нийтлэлд онцгой сайн зүйрлэл элбэг байдаг. Зохиолын шоглох зүйрлэл нь бичигдэж байгаа хүнийг ямар нэгэн юмтай жиших биш, харин дутагдлыг нь товойлгон харуулахуйц зүйрлэл байх хэрэгтэй.

Жишээ нь төрийн хошой шагналт зохиолч Д. Сэнгээ «Модчин» шогтоо юмаар юм хийж чаддаггүй хүнийг үзүүлжээ. Нэг мужаан тэрэгний гол хийх гээд цавчсаар байгаад болсонгүйд сүхний иш хийх гээд бас чадаагүй байна. Тэгэхээр нь ээрүүлийн иш хийх гэж оролдоод бас болж өгсөнгүйд шүдний чигчлүүр хийхээр зорж гарсан тухай тэр шогт өгүүлдэг ажээ.

Мөн нэрт шогч Л. Бадарчийн бичсэн «Толь Гэндэнгийн үг» шогт дамын худалдаачдын байдлыг дүрслэхдээ: «Тоотой гүүгээ тав саагаад Толгойтын голыг арав саагаад», «Цөгц шиг шанагаа бариад, богц шиг түрүүвчээ өвөртлөөд» гэх зэргээр зүйрлэсэн байдаг. Айрагт ус хийдгийг Толгойтын гол саасан гэж, бусдад худалдах шанага нь цөгц шиг жижиг атал, бусдаас авах мөнгөний түрүүвч нь богц шиг том байна гэж зүйрлэжээ.

Хошин, шог зохиол, нийтлэлд адилтгал, зүйрлэл, ихэсгэл, давуулал, хэтрүүлэл зэргийг өргөн ашигласнаар шоглосон, хошигносон, егөөдсөн, ёгтолсон өнгө аясыг бий болгодог. Энэ нь зохимжгүй хэллэгийг хэр хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэнэ гэсэн үг биш. Хэрэв хэтрүүлэн хэрэглэвэл хошин, шогийн уг мөн чанар алдагдана.

Шог инээдэм бол амьдралд оршиж буй муу муухайг эсэргүүцэж, ёс суртахууны ялалт байгуулдаг. Үүний үр дүнд хүний сэтгэлийн хөдөлгөөнөөр инээдэм өөрийн эрхгүй бий болдог. Иймээс шог, инээдэм хоёрыг ялгах шаардлагатай болно. Судлаач Ц. Тогоочийн тэмдэглэснээр, шог гэдэг бол шүүмжлэл юм. Гэхдээ инээдэм дагуулсан байдгаараа онцлогтой. Тэгвэл инээдэм бүхэн хошин, шог биш. Харин хошин, шог бүгд инээдэм юм⁷. Иймээс л шог гэдэг бол шүүмжлэл, учиртай инээдэм хоёрын нэгдэл болдог байна. Хошин, шог нь байгальд байдаггүй, хүмүүсийн үзэл суртал, зан харьцаанд оршдог. Аливаа юмны зохицол алдагдаж, муу муухай гэж үнэлэгдсэн зүйлээс арчаагүй чанарыг олох нь шог инээдэм

«

*Хошин инээд бол амьдрал
урлагийн аль алинд хамгийн
түгээмэл дэлгэрсэн байдаг. Уран
хошин үг хэлдэггүй хүн, уран
хошиноор дүрсэлж үзээгүй
зохиолч гэж бараг байхгүй юм.*

*Хошин зохиолд уран
бүтээлчийн сайн сайхны хүсэл
эрмэлзлийн дагуу үзэгдэл
дүрслэгддэг.*

»

болдог. Тэгэхдээ инээдэм нь гоо сайхны эрхэм дээд эрмэлзэл, нийгэм, хамт олны үзэл бодолд бүрэн дүүрэн нийцэж байж сая жинхэнэ инээдэм болж чадна. Жинхэнэ инээдэм бол нийтэд ойлгомжтой, сургамжтай, санаа авууштай идэвхтэй шүүмжлэл болдгийнхоо хувьд ихээхэн ач холбогдолтой. Чухамдаа эндээс инээдмийн зохиолын мөн чанар, өвөрмөц онцлогийг нээн тодруулах шаардлага зүй ёсоор урган гарч ирдэг билээ.

Дүгнэж хэлбэл, инээдмийн зохиол, нийтлэлийн үндсэн онцлог нь хамгийн бадрангуй дэвшилт үзэл, үйл явдлын сонирхолтой нарийн зохиомж, инээд баясал төрүүлэх чадвар, дүрүүдийн ялгавартай тод шинж төрх, оновчтой, баялаг, товч тодорхой мэргэн цэцэн үг хэллэг юм.

Нийгмийн тодорхой анги, бүлгийн үзэл суртал, хэв заншлыг өөртөө шингээсэн тухайн хүмүүсийн аж амьдрал, зан суртахууны алив үзэгдэл, байдлыг хүнд өдөр тутам ойлгогдон ажиглагддаг, ерийн хэвшсэн шинж талаас нь биш, огт санаанд оромгүй шинж, өөр өнцгөөс олж харж, агуулга санаагаа сонирхолтой хэлбэрээр оновчтой мэргэн илэрхийлж чадсан байдаг нь инээдэмт зохиолын өвөрмөц шинж юм. Хошин, шог зохиол, нийтлэлийн өөр нэг онцлог нь хэзээ боловч цаг үеэ олсон асуудлыг дэвшүүлдэг хурц дайчин давшингуй шинж мөн.

Хошин, шог зохиол, нийтлэл санамсаргүй зүйлийг олж, үнэмшил төрүүлэх замаар зайлшгүй тодорхой зүйлийг илрүүлдэгийнхээ хувьд ч, бодит байдлыг дүрслэх өвөрмөц арга барилд тохирсон уран оновчтой, яруу тодорхой, мэргэн ухаалаг үг хэллэгтэй байдгийнхаа хувьд ч уран бүтээлчдээс хурц ухаан, онцгой авьяас билэг байнга шаардаж байх харьцангуй хэцүү хэлбэр юм. Энэ нь түүний гол онцлогийн нэг билээ. Ер нь сэдэн олох хурц ухаан, санамсаргүй тохиол хоёр хошин, шог зохиол бичигчдэд агаар, ус мэт

хэрэгтэй зүйл мөнийг хэзээ боловч онцолж үзэх учиртай. Нийгмийн аливаа юм үзэгдлийн нааштай тал, эсрэг талыг овжин гярхай олж харж, ялган тунгааж, элэг хөшим уян зөөлөн, уур хүрэм, хорон гашуун болгож, санамсаргүй сонин хэлбэрээр үзүүлж чадах нь зохиолчийн уран чадварын маргашгүй давуу шинж мөн. Инээдмийн шилдэг бүтээл бичихэд анхаарах хоёр зүйл байдгийг судлаач Ши. Цэнд-Аюуш онцолжээ. Үүнд: нэгдүгээрт, жинхэнэ уран сайхны инээдэмт хурц тод дүр бүтээх юм. Үүнийг хэрэгжүүлэх үндсэн зам нь зохиолын баатрын бодол санаа, төрөлх авир араншин, үзэл санаанд үнэнхүү нийцсэн, тэдний хэн болохыг товойтол харуулж чадах, хэнд яаж хандаж байгаагаа бүрэн дүүрэн илэрхийлсэн адтай онож хэлсэн үг хэллэг мөн. Хоёрдугаарт, хэн хүний ухаанд дав даруй орж ирэхэд хэцүү, гайхалтай сонин санаа зохиомж ашигласан байх шаардлага хошин, шог зохиол, нийтлэлийн хувьд хамгийн гол, хамгийн чухал зүйл болж дэвшигддэг. Үүнд зохиолын онц сонирхолтой үйл явдал, уран нарийн хэтрүүлэл, алив нэг юм үзэгдлээр далимдуулан өөр юм үзэгдлийн тухай уран хошиноор өгүүлэх чадвар, далд утгаар мохоон буруутгах эв дүй мэт олон зүйл хамаарагдаж болно.

Хошин, шог зохиолыг ойлгох, үнэлэх хандлагын тухайд гэвэл, юуны урьд хошин, шог зохиолын шүүмжлэл нь ахуйн болон ажил төрлийн энгийн шүүмжлэлээс чанарын болон зарчмын ялгаатай юм. Инээдэм бол шүүмжлэлийн өвөрмөц хэлбэр, чухамхүү хурц сэтгэлийн хөдөлгөөнөөр илрэх онцлог шинж, үзэл санаа сэтгэл зүйн ухамсартай идэвхтэй ойлголт хандлага бүхий шүүмжлэл болно. Шог зохиол дайралдсан бүхнээ шүүмжилдэггүй, заавал учир шалтгаантай юмыг өөрийнхөө аргаар, өөрийнхөө нүдээр харж тодруулан буруутган үзүүлдэг. Тэрчлэн хошин, шог зохиол цаг ямагт муу муухайг шүүмжилж байдаг бус, ололт амжилтыг бахдан үзүүлэх нь бий⁸.

Дутагдлыг илчлэх, үүний зэрэгцээ ололтыг харж, амжилтыг үнэлэх, үүнийгээ нийгмийн тэргүүний үзэл санааны үүднээс бататган өгөх нь хошин, шог зохиолын нэг үүрэг мөн.

Цаг үеийн захиалгаар бий болж, бойжсон шүүмжлэлт шог зохиол тухайн нийгмийнхээ дутагдал доголдол, шударга бус явдал, харгис бурангуй үзэл, хүний хомхой сэтгэл, хөгжил дэвшилд чөдөр тушаа болж буй бүхнийг илчлэн шүүмжилж, олон нийтийн санаа бодлыг бүрэлдүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн юм.

Хаана шүүмжлэл байхгүй бол тэнд элдэв төрлийн дутагдал, хоцрогдол, янз бүрийн ялзрал гардаг⁹.

Шүүмжлэлт шог зохиол, нийтлэл улс үндэстний амьдралд хувьсгалт эргэлт, өөрчлөлт гарах үед хөгжин цэцэглэж байсан нь гүнзгий учиртай. Жишээ нь, Сэргэн мандалт (Рабле, Сервантес), Соён гэгээрэл (Свифт, Вольтер), Германы 1848 оны хөрөнгөтний хувьсгал (Гейне, Веерт), XIX зууны 60-аад онд Орос оронд өөрчлөлт гарах тохироо бүрэлдэж байх үед (Салтыков-Щедрин, Некрасов) шүүмжлэлт зохиол ихээхэн хөгжжээ.

Хошин, шог зохиол, нийтлэл нь нийгмийн дэвшил, хөгжилд чөдөр тушаа болж буй хоцрогдсон үзэл санаа, бурангуй өтөл бэртэгчин явдлыг уран сэтгэмжийн аргаар үнэн бодитой дүрслэн үзүүлэх ёстой. Энэ шинжийг дэлхий дахины нэрт хошин, шогчдын уран бүтээлээс ажиглаж болно. Тэд бүтээл туурвилдаа нийгэм дэх үеэ өнгөрүүлсэн, улиглан хоцрогдсон юм, үзэгдлийн ерөнхий хэв шинжит дүрийг урлаж, шоглон шүүмжилдэг байжээ.

Шоглох, хошигнох мэдрэмж бол гоо зүйн дээд үзэл бодолд суурилдаг. Хэрэв эс тэгвэл шоглол, хошигнол нь бусдыг доромжилсон бүдүүлэг өөдгүй тохуурхал болж хувирна. Чухамдаа шоглол, хошигнол нь гоо зүйн өндөр соёлтой, үзэгдэл юмсын мөн чанарт шүүмжлэлтэй ханддаг, аливааг хооронд нь санаанд оромгүй байдлаар

харьцуулан жишиж чаддаг жинхэнэ авьяаслаг уран бүтээлчийн ажил мөн. Аристофан (Грек), Эзоп (Грек), Мольер (Франц), Рабле (Франц), Сервантес (Испани), Грибоедов, Гоголь, Крылов, Салтыков-Щедрин, Чехов (Орос) нар хүн төрөлхтний оюуны соёлд зүй ёсоор мөнхөрчээ. Монголын «Далан худалч», «Бэлэн Сэнгэ», хуульч Сандаг, Д. Равжаа. Агваанхайдав, Гэндэн мэирэн, ойрх цагийн Д. Нацагдорж, Ц. Дамдинсүрэн, С. Буяннэмэх, Л. Бадарч, Ч. Ойдов, Л. Ванган, Н. Иштавхай, Ц. Доржготов, Шаг. Цэнд-Аюуш, Ж. Барамсай, И. Цэрэнжамц, Г. Дамба, Б. Цэнддоо зэрэг уран бүтээлч улс үндэстний хэмжээнд үнэлэгдэх хошин, шог бүтээлээрээ алдаршжээ. Крыловын ёгт үлгэр бол жинхэнэ орос үндэстний бахархал, Гоголийн хэтрүүлэл нь уугуул оросын нулимстай инээд, Сандаг, Равжаа, Агваанхайдав, Гэндэн мэирэн нарын цаг үе, анги давхаргатайгаа тооцоо бодсон хурц шоглол, аймшиггүй эр зориг, Л. Бадарчийн тохуу даажинтай хөхүүн инээд, Л. Ванганы гэм хоргүй егөөдөл хошигнол, Ц. Доржготовын ухаалаг бясалгалын аяст шоглол, Шаг. Цэнд-Аюушийн уран дэврүүлэлт инээд, Ж. Барамсайн дайчин хурц шоглол, хошигнол, элэглэл, И. Цэрэнжамцын ухааны бярттай, донжтойхон тохуурхал, Д. Пүрэвдоржийн цэцэн цэлмэг дүрслэл бүхий шог инээд, З. Ядмаагийн зугаатай хошигнол, М. Дэмчигийн цөөхөн үгэн дэх шоглол, Б. Цэнддоогийн уран элэглэл нь цөм ухааны ураас эхтэйг хошин, шог зохиол судлаач Ш. Гүндалай онцгойлон үнэлжээ¹⁰.

Хошин, шог зохиолын гол зорилго бол амьдрал дахь муу муухай явдал, дутагдал доголдлыг илрүүлж, түүний эсрэг чиглэн оновчтой, үнэмшилтэй дүрсэлснээрээ хуучин хоцрогдсоныг үгүйсгэж, дэвшилттэй шинийг нотлон зөвтгөдөг.

Шог зохиолын шүүмжлэл бол ерөнхий шүүмжлэл бус сэтгэлийн хөдлөл, хүний сэтгэлгээний ариун нандин

чанар, эрүүл саруул инээдмээр илрэх шүүмжлэл юм. Үүнээс үндэслэн шог зохиолын өвөрмөц онцлог гарч ирдэг бөгөөд судлаач С. Лувсавандангийн тодорхойлсончлон:

— Шог зохиол ямагт цаг үеэ олсон асуудлыг дэвшүүлдэг хурц дайчин шинжтэй.

— Шог зохиолд санамсаргүй зүйл гол байр эзэлдэг. Тэгэхдээ зайлшгүй зүйлийн тодорхой онцлог илрэл болдог.

— Шог зохиол бодит байдлыг дүрслэх өвөрмөц арга барилд тохирсон уран сайхны дүрслэлийн онцлог хэрэгслийг шаардана. Энэ бол шог зохиолын хэл юм. Шог зохиолын үг хэллэг хурц, яруу тод, мэргэн цэцэн, тэгэхдээ гашуун хорон байдаг¹¹.

Хошин, шог нийтлэл бол ямагт нийгмийн шинжтэй байдаг онцлогтой. Нэг үгээр хэлбэл хошин, шог нийтлэлийн баатар нь бодитой хүн, тэгэхдээ гэм дутагдалтай нэгэн этгээд байдаг. Мөн хошин, шог нийтлэлийг аль ч төрөл, зүйлээр бичсэн байлаа гэсэн тухайн хүний эрхэлсэн албан тушаал, аймаг, сум, баг, дүүрэг гэх мэт засаг захиргааны харьяалал, нэр ус хөдөлшгүй баримтаар заадаг.

Хошин, шог зохиолыг марзагнал төдий ойлгож хэрхэвч болохгүй. Учир нь ийм төрлийн зохиолыг зөвхөн

инээлгэх зорилгоор бичдэггүй. Бас заавал муу юмыг бичдэг хэрэг биш. Шог зохиолд амьдралаас тасархай хэтрүүлэг, давуулал хэрэглэх нь зохимжгүй. Саар зүйлийг шүүмжлэхдээ сайн зүйлийг сурталчилж болдог. Хошин, шог зохиол бичих нь уг шүүмжлэн элэглэж үзүүлэх гэж байгаа зүйлээ хичнээн зүрх сэтгэлээсээ үзэн ядаж чадсанаас урлах оньс нь гардаг¹².

Монголын хошин, шог хэвлэл дэх хошин, шогийн харьцааг гаргах зорилгоор бид 1945, 1955 оны «Матар», 1965 оны «Хүмүүжил жигшил», 1975, 1985, 1995, 2005 оны «Тоншуул» сэтгүүлийн нийт 84 дугаарын нийтлэлд агуулгын задлан шинжилгээ хийлээ. Ингэхэд 1940-1980-аад оны үед шог нийтлэл давамгайлж байсан, харин 1990 оноос хойш хошин нийтлэл зонхилох болсон нь харагдаж байна (№1).

Энэ нь сэтгүүл зүйн үүрэг, зорилгоос шууд хамааралтай. Коммунист хэв загварын сэтгүүл зүйн үед аж төрөх социалист ёсонд харшилж буй үзэгдэл, дутагдлыг тээгч этгээдийг нэр ус заан шүүмжилж, жигшүүлэх үүднээс шоглодог байсан бол чөлөөт ардчилсан сэтгүүл зүйн үед хүний эрхийн асуудал хурцаар тавигдах болж, улмаар сэтгүүлч, нийтлэлчид юм, үзэгдлийн дутагдлыг хошигносхийгээд өнгөрөөх болсон байна.

Хошин ба шог нийтлэл

Он	Хошин		Шог		Нийт
1945	19	25%	57	75%	76
1955	10	9%	102	91%	112
1965	21	18%	94	82%	115
1975	36	18%	169	82%	205
1985	41	24%	132	76%	173
1995	61	53%	55	47%	116
2005	175	56%	140	44%	315
	363	33%	749	67%	1112

1940-1960-аад оны хэвлэлд хэн нэгний гэм зэмгүй төөрөгдөл, хөгтэй явдлыг хошигнохоос илүүтэйгээр гэм

дутагдалтай этгээдийг хурцаар ёгтлон шоглосон нийтлэл тооны хувьд давамгайлж байв.

1970-аад онд хүн чанараа алдагсад, бялдуучид, хүнд сурталтнууд, төлөвлөгөө таслагчид, шинэ санаачилга үл гаргагчдыг зүйл бүрээр баалан шоглосон нийтлэлийн буухиа улам эрч хүчээ авээ. Гэхдээ зарим нэг сэдвээр тун мохоо нийтлэл бичигдэж байсан нь ч ажиглагддаг.

1980-аад онд аливаа гэм дутагдлыг уудлан илчилсэн шог нийтлэлээс гадна хувь хүний санамсаргүй төөрөгдөл, санаандгүй будилсан хөгтэй явдлыг хошигносон хошин нийтлэл ч багагүй нийтлэгдэх болсон байна. Ялангуяа ноцтой гэм дутагдлыг шоглолгүй тэгэхээд хошигноод өнгөрсөн хошин өгүүлэл олон байсан нь харамсалтай.

1990 оноос хойш хошин, шог нийтлэлийн харьцаанд өөрчлөлт гарчээ. тухайд: Улс оронд ардчилсан хувьсгал ялснаар нийгэм, эдийн засаг, соёлын амьдралд ихээхэн өөрчлөлт гарсан нь сэтгүүл зүйг, түүний дотор хошин, шог нийтлэлийг ч тойрсонгүй. Муу малчин, хариуцлагагүй ажилчин, төлөвлөгөө нураасан бага албан тушаалын даргыг хайр найргүй шүүмжилж шоглодог уламжлал үеэ өнгөрөөсөн байна. Үзэл суртал түүхийн хуудас руу улиран одсоноор хошигносон өнгө аястай нийтлэл зонхилох болжээ.

Монгол улсын шинэ Үндсэн хуулийн «Хүн үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх... эрх чөлөөтэй» заалт бодит зүйл болсноор нийгмийн аливаа гэм дутагдлыг ямар ч дарамт шахалтгүйгээр сэтгүүлчид мэдээлэх таатай эрх зүйн орчин бүрдсэн билээ. Үүнийг нэг талаар нийгмийн аливаа гэм хортой зүйлтэй эвлэрэхгүйгээр чөлөөтэй ёгтлон шоглох нөхцөл бүрдсэн гэж ойлгож болно. Ялангуяа ерээд он гарснаар хошин, шогчид улс төрийн сэдвээр нилээд чөлөөтэй бичиж эхэлсэн нь ажиглагддаг. Нөгөө талаас шоглон ёгтолсон хурц бичлэгтэй нийтлэл хөгжих эрх зүйн энэ үндэс нь эргээд чөлөөтэй сэтгэн бичсэн хошин хэлбэрийн нийтлэл ч олноор

нийтлэгдэхэд хүргэсэн содон зүйл ажиглагдаж байгаа нь сонирхолтой юм.

2000 он гарснаар нийгмийн аливаа гэм дутагдлыг шоглох хошигнох явдал ч, харьцангуй чөлөөтэй сэтгэх сэтгэлгээ ч хөгжиж эхэлжээ. Орчин үеийн хошин, шог сэтгүүл зүйд егөөдсөн хошин нийтлэл зонхилох болсон явдал юм. Ер нь ерээд он гарснаар шог нийтлэл хошин нийтлэл тооны хувьд цөөрсөн ч үнэ цэнэ нь буураагүй. Харин ч өсөн нэмэгдэж илүү далайцтай даацтай хурц дайчин болж, илүү туршлагажсан нь илт мэдрэгддэг.

Ишлэл

¹ Мөнх Ц. Бодит байдалд харьцах яруу сайхны харьцаа // «Цог» сэтгүүл, 1968, №3.

² Сампилдэндэв Х. 1990. Яруу найргийн хошин, шог зохиолын уран чадварын асуудалд // Утга зохиолын шүүмжлэл. УБ., х. 25.

³ Сампилдэндэв Х. 1998. Хошин, шог шүлгийн уран чадварын асуудалд // Яруу найргийн уран санаа. УБ., х. 9.

⁴ Гүндалай Ш. 2005. Монгол хошин, шог өгүүллэг. УБ., х. 12-13.

⁵ Лувсанвандан С. 1973. Хошин, шог зохиолын учир // Монголын орчин үеийн уран зохиолын онол түүхийн асуудалд. УБ., х. 405.

⁶ Даржаа Д. Шог зохиолд зүйрлэл хэрэглэх асуудал // «Хөдөлмөр» сонин, 1960, №15.

⁷ Тогооч Ц. Шог инээдмийн зохиолын тухай // «Улаанбаатарын мэдээ» сонин, 1970, №87.

⁸ Цэнд-Аюуш Ши. 1988. Далаад оны инээдмийн зохиол // Уран сайхны шүүмжлэлийн тухайд. УБ., х. 74.

⁹ Даржаа Д. Шүүмжлэл, өөрийн шүүмжлэлийн нэн хурц хэлбэр бол инээдэмт шог зохиол, шог зураг // «Үнэн» сонин, 1951, №60.

¹⁰ Гүндалай Ш. 2005. Монгол хошин, шог өгүүллэг. УБ., х. 11-12.

¹¹ Лувсанвандан С. Шог зохиолыг элбэгжүүлбэ // «Соёл, утга зохиол» сонин, 1964, №29.

¹² Даржаа Д. Хошин, шог зохиол // «Утга зохиол, урлаг» сонин. 1969, №37.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Гаадамба Ш. 1989. Утга зохиолын онолын үндэс. УБ.
2. Гүндалай Ш. 2005. Монгол хошин, шог өгүүллэг. УБ.
3. Гүндалай Ш. 1989. Хошин, шог зохиол. УБ.
4. Дулам С., Хасбаатар Ц. 1980. Уран зохиолын онолын үүд. УБ.
5. Зулькафил М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
6. Норовсүрэн Л. 2000, 2001, 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. I, II, III дэвтэр. УБ.
7. Стрельцов Б. В. 1983. Фельетон. Изд-БГУ. Минск.

8. Виленский М. Э. 1982. Как написать фельетон. М.

Резюме

Статья посвящена сущности и специфике двух начал — юмористического и сатирического. Автор на основании анализа публикаций таких изданий как "Воспитание и презрение", "Крокодил" и "Дятел" рассматривает развитие монгольской сатирической журналистики, особенности её становления и развития за прошедшие 60 лет. Автором были выявлены специфические черты публикаций каждого из вышеназванных журналов.